

ХЯТАД, АФРИКИЙН ОРНУУДЫН ХАРИЛЦАА ӨЧИГДӨР, ӨНӨӨДӨР

3. Эрдэнэчимэг

БНХАУ тунхагласнаас хойш 40 жил өнгөрлөө. Дэлхийн II дайны дараа колонийн импери задрах үйл явц эхэлж байсан түүхэн нөхцөлд Хятад орон хагас феодал, хагас колонийн гав гинжийг таягдан хаяж ардын бүгд найрамдах засаг тогтоосон явдал колонийн орнууд, түүний дотор Африкийн ард түмний империализм, колоничлол, арьс өнгөөр гадуурхан ялгаварлах бодлогын эсрэг хийж байсан шударга тэмцлийг улам зоригжуулж, үндэсний тусгаар тогтнолоо байлдан олоход нь зохих түлхэц болсон юм.

Өнгөрсөн 40 жилийн хугацаанд орчин үеийн олон улсын харилцааны түүхэн нөхцөлөөс үүдэн БНХАУ-ын олон улсын тавцанд эзлэх байр суурь, дэлхийн улс түмэнтэй харилцах харилцаанд янз бүрийн өөрчлөлт гарсаар иржээ. Гэвч ямар ч нөхцөлд Хятад улс нь хөгжиж байгаа орнууд түүний дотор Африкийн орнуудтай эв нэгдэл, хамтын ажиллагаагаа хөгжүүлэн бэхжүүлэх явдлыг гадаад бодлогынхоо үндсэн чиг шугамын бүрэлдэхүүн хэсэг болгож, зарчмын хувьд баримталж байсныг тэмдэглэх хэрэгтэй юм.

БНХАУ-ын Төрийн зөвлөлийн ерөнхий сайд Ли Пэн 1989 оны 3-р сарын 20-нд БХАТИХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн 2-р чуулганд тавьсан засгийн газрын ажлын тухай илтгэлдээ «Африкийн орнуудтай эв нэгдэлтэй хамтран ажиллах нь Хятадын төрийн гуйвшгүй бодлого юм» гэж мэдэгдсэн байна.¹

БНХАУ өөрийгөө «гурав дахь ертөнцөд» хамаарагдах орон гэж үздэг билээ. Иймд Хятад ба хөгжиж буй орнуудаас зонхилох байр эзлэх Африкийн орнуудын хоорондох гучаад жилийн түүхтэй харил-

1. «Дорнодахины судлалын асуудал» № 2. (19). 1988, х, 31
2. «Документы XIII Всекитайского съезда КПК» Пекин, 1987, с. 29
3. «Жэньминь жибао», 1988. 8. 26
4. «Тоа» сэтгүүл, 1988. 4, №250 х. 17 (япон хэлээр)
5. Чюүкоку (Хятад улс) 1988. Токио, 1988, х, 128, (япон хэлээр)
6. «Тоа» сэтгүүл. 1988. 11 №257, 17 (япон хэлээр)
7. Чюүкоку. (Хятад улс) 1988 Токио, 1988. х. 128. (япон хэлээр)
8. Чюүкоку (Хятад улс). 1988. Токио, 1988, х, 128, (япон хэлээр) ,
9. Чюүкоку (Хятад улс) 1988, (Япон хэлээр)
10. Тоа» сэтгүүл., 1988. 11, №257, х. 19
11. Чюүкоку (хятад улс), 1988. Токио, 1988, х. 129, (япон хэлээр)
12. Жэньминь жибао, 1988. 8. 26
13. «Тоа» сэтгүүл, 1988. 4. №250 х 20 (Япон хэлээр)
14. Чюүкоку (Хятад улс), 1988. Токио, 1988. х. 130
15. Чюүкоку (Хятад улс), 1988, Токио, 1988, х. 130
16. Чюүкоку (Хятад улс), 1988, Токио, 1988, х. 130,
- 17, «Тоа» сэтгүүл, 1988, 11, х, 14
18. «Жэньминь жибао», 1988. 8. 27
19. «Тоа» сэтгүүл, №257, 1988. 11, х. 14
20. «Жэньминь жибао» 1988. 8. 27.
21. «Тоа» сэтгүүл, №257, 1988, 11, х. 14

цаа ямаршуухан байдалтай хөгжиж ирснийг товч танилцуулахад энэ өгүүллийг зориулав.

БНХАУ одоо Африкийн 48 оронтой дипломат харилцаатай юм. 50-иад оны үед энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмын үндсэн дээр БНХАУ Африкийн ард түмний үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцлийг бүх социалист орнуудын хамт эрс шийдвэртэй дэмжиж сэтгэл санааны болон бусад талын тусламж үзүүлж байлаа. Гадаад бодлогын энэхүү улс төрийн чиг шугам нь хүйтэн дайны нөхцөлд империализмын сүр хүчийг задлан бутрааж, даян дэлхийд энх тайвныг сахин хамгаалахад чухал хувь нэмэр болсон юм.

60-аад оны үед БНХАУ Африкийн нэлээд оронтой дипломат харилцаа тогтоож, олон улсын харилцааны тавцан дээр улс төр, дипломатын талаар хамтран ажиллаж ирэв. Энэ үед улс орнуудын харилцаанд, түүний дотор Хятад ба социалист хамтын нөхөрлөлийн орнуудын улс төрийн харилцаанд өөрчлөлт гарч, олон улсын асуудлаар санал зөрөлдөөн үүсч байсан нөхцөлд Хятадаас Африкт үзэл суртлын шинж чанартай бодлого явуулж байсан бол 70-аад оны үед эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, Африкийн зарим оронд техник, эдийн засгийн тусламж үзүүлж эхэлсэн байна. Харин 80-аад оноос улс төрийн харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааг улам өргөжүүлэх бодлого баримтлах болсон бөгөөд Өмнөд-Умардын харилцааг сайжруулах, Өмнөд-Өмнөдийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхийг чухалчилж, энэ талаар Африкийн орнуудын гаргаж байгаа хүчин чармайлтыг дэмжиж эхлэв. Дээрх чиг бодлогын үүднээс хятадын удирдах хүмүүс, Африкийн удирдах хүмүүсийн харилцан айлчлах явдал өргөн хүрээтэй болсон байна. Жишээлбэл, 1957 оны 3-р сараас 1986 оны 12-р сар хүртэл Хятадын 20 гаруй удирдах хүмүүс Сахараас урагш орших 31 орноор 88 удаа айлчилсан бол мөн хугацаанд тус бүс нутгийн 39 орны төр, засгийн тэргүүн нар Хятадад 117 удаа айлчлав.² Эдгээр айлчлал нь Хятад, Африкийн орнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэв. Үүний үр дүнд Хятад, Африкийн орнуудын хооронд олон тооны гэрээ, хэлэлцээр байгуулж, хамтран ажиллах боломжийг нээсэн байна. Тухайлбал, 1986 оны эцэс гэхэд Хятадын засгийн газраас Сахараас урагш орших 40 гаруй оронд эдийн засгийн тусламж, үзүүлж иж бүрэн 448 объект байгуулж өгөхөөс 318-ыг байгуулж дуусгажээ³.

Хятад улс Бурундид хөвөн нэхмэлийн үйлдвэр байгуулж өгснөөр тус орон өөрийн хэрэгцээг хангаж чадахуйц болжээ. 35000 ам дөрвөлжин метр талбай эзлэх уг үйлдвэр нь ээрэх, нэхэх, будах, механик зэрэг 4 том цехээс бүрдэж байгаа ба 1700 ажилтантай. 1980 онд ашиглалтад орсноос хойш ажил нь өөдрөг сайн явж байгаа төдийгүй уг үйлдвэрийн бүтээгдэхүүн 1986 оноос Мадридад алтан медаль хүртжээ. 1986 оноос төслийнхөө чадлыг бүрэн ашиглах болсон ба жилдээ 4 сая долларын ашигтай ажиллаж байна. 1700-аад төрлийн гоёмсог хээ хуартай даавуу гаргадаг болсон нь Бурундийн бүсгүйчүүдийн хэрэгцээг хангах болжээ.⁴

Одоо Хятад улс тус бүс нутгийн 41 оронтой худалдааны харилцаатайгаас гадна 34 оронтой соёлын хэлэлцээр байгуулж хамтран ажиллаж байна.

БНХАУ 80-аад оны эхэн үед Халуун бүсийн болон Африкийн өмнөд хэсгийн орнуудтай харилцаагаа өргөжүүлж ирсэн бол 80-аад оны дунд үеэс Баруун, Төв, Дорнод Африкийн орнуудтай өргөн харилцаатай болжээ. Мөн Хятадын засгийн газар Өмнөд Африкийн эрх баригчдын арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах бодлогын эсрэг хэл-

бэрэлтгүй тэмцэж, «фронт хавийн» улсуудын ард түмний шударга тэмцлийг дэмжсээр байна.

1985 оноос Хятад улс Африкийн социалист чиг баримжаат орнуудтай харилцаагаа сайжруулах болов. Тухайлбал 1985 онд Анголын засгийн газрын төлөөлөгчид Хятадад айлчилж, хятадын тусламжтай Анголд хөнгөн үйлдвэр байгуулах төлөвлөгөөг боловсруулжээ. Мөн оны намар Хятад-Анголын хооронд хоёр талын хамтын ажиллагаа, худалдааны асуудал эрхэлсэн Эдийн засгийн Зөвлөлийг байгуулжээ.⁵ Мөн Ангол-Хятадын хооронд хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах хэлэлцээрт гарын үсэг зурсан байна. Анголд байгалийн гамшиг тохиолдсонтой холбогдуулан Хятадын тал 1984 оноос хойш бүгд 5000 тонн үр тариа нийлүүлжээ.

Хятад-Мозамбикийн харилцаа өргөжих хандлагатай байна. 1985 оны 6-р сард Мозамбикийн тусгаар тогтнолын 10 жилийн ойн баярт Хятадын нам засгийн төлөөлөгчид оролцжээ. Мөн Мозамбикийн ФРЕЛИМО намын төлөөлөгчид Хятадад айлчилсан ба энэ айлчлалын үеэр тус хоёр орны эдийн засаг, шинжлэх ухаан техникийн болон соёлын хамтын ажиллагааг 1990 он хүртэл сунгах баримт бичигт, түүний дотор Мозамбикийн Бейра хотод паалантай сав үйлдвэрлэх Хятад-Мозамбикийн хамтарсан үйлдвэр байгуулах хэлэлцээр гарын үсэг зурсан байна⁶.

Хятад-Танзанийн найрамдлын гэрээний 20 жилийн ойг 1985 оны 2-р сард Танзанид өргөн тэмдэглэв. Ер нь Африкийн орнуудаас Хятадтай өргөн харилцаатай орны нэг бол Танзани улс юм. 1985 оны 1-р сард Танзанийн ерөнхийлөгч Дж. Ньерере Хятадад айлчлах үеэр БНХАУ-ын дарга асан Ли Сяньнянь Хятад-Танзанийн харилцааг өндрөөр үнэлж «Цаг үеийн сорилтыг давж, амьдрах чадвартайгаа харуулав»⁷ гэсэн байна. Тус хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа ч Хятад, Африкийн бусад орныг бодвол өргөн хүрээтэй юм. 1970 оноос өмнө хоёр орны худалдаанд Танзанийн экспорт толлож, худалдааны нийт хэмжээ нь 15—20 сая америк доллар болж байсан бол дараа нь Хятадын экспорт зонхилж, худалдааны нийт хэмжээ 1974 онд 71 сая америк долларт хүрчээ. 1983 онд 3,2 сая амсрик доллар хүртэл буурсан бол 1984 онд дахин 10 сая америк доллар болон өсчээ.

Ер нь Хятад, Африкийн орнуудын хоорондын худалдаа тогтвортой биш байна. Жишээлбэл, 1985 онд дээрх хоёр этгээдийн худалдааны нийт хэмжээ 30 хувиар буурсан байна⁸. Энэ нь Хятад улс Африкийн орнуудаас авах уламжлалт барааг багасгаж хүдэр, эрдэсийн зүйл авдаг болсонтой холбоотой юм. Хятад улс Африкийн орнуудаас эрдэс түүхий эд, зэс, кобальт, цинк, нефть, алмаз, фосфат, хөвөн, каучук, какао, кофе, арьс, ноос авч Африкийн орнуудад торгон эдлэл өргөн хэрэгцээний бараа, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн, химийн бүтээгдэхүүн, машин, тоног төхөөрөмжийн жижиг эд ангиудыг гаргаж байна.

Хятадаас Африкийн орнуудад үзүүлсэн эдийн засгийн тусламжийн томоохон хэсгийн нэг нь Танзани-Замбийг холбосон 1800 км урт «ТАНЗАМ» төмөр зам юм. Уг төмөр замыг барихад 500 сая доллар зарцуулсан бөгөөд 7 жилийн дараа орлогоо олж эхэлжээ. Одоо 1,3 сая зорчигч, 1,2 сая тонн ачааг жилд тээвэрлэдэг байна⁹. Сүүлийн таван жилд уг төмөр замаас 40 сая долларын ашиг олжээ¹⁰.

Улс хоорондын харилцааны зэрэгцээ Хятад улс олон улсын байгууллагын шугамаар Африкийн орнуудтай хамтран ажиллаж байна. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Программын хүрээнд Ботсвана, Буркина-Фассо, Бурунди, Кени, Мавритани, Нигер, Сом

ли зэрэг орнуудад хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэл бүхий 8 төсөлд БНХАУ оролцож байна¹¹. Эдийн засгийн тусламж үзүүлэх, техникийн талаар хамтран ажиллах Программын хүрээнд БНХАУ-аас хөгжиж буй 90 оронд тусламж үзүүлсний 46 нь Африкийн орнууд байна.¹²

1986 онд хятадын төлөөлөгчид Хараред болсон Африкийн хөгжлийн банк, Африкийн хөгжлийн фондын хамтарсан хуралд оролцож, Африкийн орнуудын нийгэм-эдийн засгийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж, эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх болно гэдгээ мэдэгдсэн байна.

Сүүлийн жилүүдэд БНХАУ Африкийн орнуудад хөдөө аж ахуйг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулахад нь оролцох, хөнгөн үйлдвэр, байгуулах, үр тариа цайруулах төв барих, загас агнуур, мал аж ахуйг хөгжүүлэх, цахилгаанжуулах, хөдөө орон нутагт усан хангамж байгуулах зэрэг өргөн цар хүрээтэй хамтын ажиллагааг явуулж байна.

Сүүлийн хэдэн жил Африкт ган гачиг зэрэг байгалийн бэрхшээлээс болж олон орны эдийн засаг нэлээд хүнд байдалд орж, хүн ам нь өлсгөлөн, өвчин эмгэгт нэрвэгдэж байна. Үүнтэй холбогдуулан БНХАУ-аас Африкийн олон оронд нэлээд хэмжээний тусламж үзүүлж иржээ. Тухайлбал, Этиопт 1983 онд 40 мянган быр (Этиопийн үндэсний валют) -ын тусламж үзүүлсэн бол 1985 онд 25 мянган тонн буудай, 1 мянган ш. бүтээлэг хөдөө аж ахуйн багаж хэрэгсэл нийлүүлжээ.¹³ Сомалид 8 мянган тонн буудай, эмнэлгийн багаж хэрэгсэл, мал аж ахуйн төв барихад нь зориулж 345 мянган америк доллар олгохоор болжээ.¹⁴ Гвинейд 1 мянган тонн хүнс тэжээл, 19 тонн эм, Бенинд 23,5 сая африк франкийн өртөг бүхий эм болон эмнэлгийн тоног төхөөрөмж, Мозамбикт 500 мянган долларын тусламж тус тус үзүүлсэн байна.¹⁵

1989 оны 4-р сард Тогогийн ерөнхийлөгч Г. Эйадема Бээжинд айлчилж БНХАУ-ын дарга Ян Шанкуньтай хэлэлцээ хийх явцад «Африкийн орнуудын үр бүтээлтэй хамтын ажиллагаа, сэтгэл харамгүй тусламж дэмжлэг нь Африкийн орнууд дэлхийн эдийн засгийн тэгш бус дэнсэн дээр өөрийн жингийн туухайг нэмэхэд тус нэмэр болж байна»¹⁶ гэж хэлсэн нь хөгжиж байгаа орнуудын гол гишүүн болох Хятад улсад Африкийн орнууд ихээхэн найдлага тавьж байгаа нь илт байна.

Учир иймд олон улсын эдийн засгийн шударга дэглэм тогтоохын төлөө БНХАУ Африкийн орнуудтай хамтран тэмцэх бодлого баримтлах нь зүйн хэрэг болж байна.

1. «Жэньминь жибао», 1989. IV. 6
2. «Жунго вайжяо гайлань» (Хятадын гадаад харилцааны тойм). Бээжин, 1987., 148-р тал
3. Мөн тэнд, 149-р тал
4. «Жэньминь жибао», 1989. VI. 7.
5. КНР: политика, экономика идеология. М., 1988, 223-р тал
6. «Нотисиаш». 03. 10. 1985. КНР: политика, экономика, идеология, М., 1988, 224-р тал
7. «Жунго вайжяо гайлань» (Хятадын гадаад харилцааны тойм) Бээжин, 1985. 160-р тал
8. КНР: политика, экономика идеология, 1986, М., 1986, 159-р тал
9. «Азия и Африка сегодня», 1989, No 7, 42-р тал
10. Мөн тэнд
11. «Чайна актуэль», 1985, No 6, 392-р тал
12. «Бээжин ревью» 1987, No 9, 30-р тал
13. «Чайна актуэль». 1985, No 3, 190-р тал, No 8, 569-р тал
14. Мөн тэнд.
15. «Чайна актуэль», 1985, N 6, 392-р тал
16. «Жэньминь жибао», 1989. IV. 8